



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 679


Улаанбаатар хот

"Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн
ажиллах журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2, 8.4, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйл, Төрийн өмчийн хорооны 2009 оны 232 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны үлгэрчилсэн журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Улсын бүртгэлийн байгууллагын "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн ажиллах журмыг хавсралт ёсоор баталсугай.
2. Журмын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга Р.Даваадоржид үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ПҮРЭВДОРЖ

Улсын бүртгэлийн ерөнхий газрын
даргын 2013 оны 67-д тоот тушаалын
хавсралт



“ӨМЧ ХАМГААЛАХ БАЙНГЫН ЗӨВЛӨЛ”-ИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Улсын бүртгэлийн ерөнхий газар /цаашид “ерөнхий газар” гэх/, аймаг, нийслэлийн улсын бүртгэлийн хэлтэс, газрын /цаашид “хэлтэс” гэх/ “Өмч хамгаалах байнгын зөвлөл” /цаашид зөвлөл гэх/-ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Иргэний хуулийн холбогдох заалт, Татварын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолоор баталсан журмын хоёрдугаар хавсралтын “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ”, Дэд бүтцийн сайдын /хуучнаар/ 2004 оны 19 дүгээр тушаалын хоёрдугаар заалтын 8 дугаар хавсралтаар тогтоосон “Автомашинны эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг норм”, Төрийн өмчийн хорооны 2001 оны 615 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгөд оруулах хөрөнгө оруулалтын зөвшөөрөл олгох, хяналт тавих, хүлээн авах, тооцож баталгаажуулах ажлыг зохион байгуулах журам”, Төрийн өмчийн хорооны 2009 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Өмч эзэмшлийн гэрээний үлгэрчилсэн загвар”, Төрийн өмчийн хорооны 2007 оны 42 дугаар тогтоолоор баталсан “Түрээсийн төлбөрийн доод үнэ, гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай журам”, Төрийн өмчийн хорооны 2012 оны 44 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам” болон төрийн өмчийн талаарх бусад хууль тогтоомж, эрх зүйн актыг мөрдлөг болгоно.

1.3. Зөвлөл нь үндсэн хөрөнгөд хамаарах үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, эргэлтийн хөрөнгийг эзэмших, зөв зохистой ашиглах, үр ашгийг дээшлүүлэхэд эрх зүйн зөвлөгөө өгөх, үндсэн хөрөнгөд бүртгэлтэй шилжүүлэх, худалдах, акталж, дансаас хасах, устгах үндсэн хөрөнгийн талаар дүгнэлт, санал гаргаж холбогдох материалыг хууль тогтоомж, журмын дагуу бүрдүүлэх, зохион байгуулах, өмч хөрөнгөтэй холбогдон гарсан хууль, тогтоомж, журмын хэрэгжилтэд хяналт тавиж ажиллана.

1.4. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31-р зүйлийн 4-д заасны дагуу зөвлөлийг Улсын бүртгэлийн хэлтэс /газар/-ийн даргын тушаалаар байгуулна.

Хоёр. Зөвлөлийн эрх, үүрэг

2.1. Зөвлөл нь байгууллагын өмч хөрөнгийг зөв зохистой, ариг гамтай ашиглахад байнгын хяналт тавьж, өмч хөрөнгөтэй холбогдон гарсан хууль тогтоомжийг сурталчилах, эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах талаар байгууллагаас зохиож буй ажил, түүний хэрэгжилт, гаргаж буй шийдвэрт хяналт тавина.

2.2. Байгууллагын эргэлтийн хөрөнгөд хамаарах хангамжийн материал, үнэт цаас зэрэг бараа материалыг шилжүүлэх, худалдах, актлах тохиолдолд бараа

материалын талаарх санал, дүгнэлт гарган, байгууллагын даргад танилцуулан, холбогдох шийдвэр гарсны дараа хэрэгжилтэнд хяналт тавина.

2.3. Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд шаардлагатай эд хөрөнгө олж авах бол эд хөрөнгийн тоо, хэмжээ, үнийн дээд хязгаар, техникийн болон бусад шаардлагын талаархи зөвлөмжийг гаргаж газар /хэлтэс/-ийн даргад танилцуулан, шийдвэр гарсны дараа холбогдох материалыг Төрийн өмчийн хорооны 2012 оны 44 дүгээр тогтоолоор баталсан журмын 1.9-1.12-д заасны дагуу бүрдүүлж, аймаг, нийслэлийн улсын бүртгэлийн хэлтэс Ерөнхий газарт, Ерөнхий газар Төрийн өмчийн хороо болон эрх бүхий байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулна.

2.4. Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх бол хүлээн авах хуулийн этгээдтэй урьдчилан зөвшилцөж, саналаа газар /хэлтэс/-ийн даргад танилцуулан, шийдвэр гарсны дараа холбогдох материалыг Төрийн өмчийн хорооны 2012 оны 44 дүгээр тогтоолоор баталсан журмын 1.9-1.12-д заасны дагуу бүрдүүлж, аймаг, нийслэлийн улсын бүртгэлийн хэлтэс Ерөнхий газарт, Ерөнхий газар Төрийн өмчийн хороо болон эрх бүхий байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулна.

2.5. Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй үндсэн хөрөнгийг худалдах бол хөрөнгийн ерөнхий болон техникийн байдлыг хөрөнгө нэг бүрээр газар дээр нь шалган дүгнэлт гаргаж, хөрөнгийг худалдах хэлбэр болон худалдах доод үнийн талаарх саналаа газар /хэлтэс/-ийн даргад танилцуулан, шийдвэр гарсны дараа холбогдох материалыг Төрийн өмчийн хорооны 2012 оны 44 дүгээр тогтоолоор баталсан журмын 1.9-1.12-д заасны дагуу бүрдүүлж, аймаг, нийслэлийн улсын бүртгэлийн хэлтэс Ерөнхий газарт, Ерөнхий газар Төрийн өмчийн хороо болон эрх бүхий байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулна.

2.6. Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй үндсэн хөрөнгийг актлах бол хөрөнгийн ерөнхий болон техникийн байдлыг хөрөнгө нэг бүрээр газар дээр нь шалган дүгнэлт, саналаа гаргаж, газар /хэлтэс/-ийн даргад танилцуулна. Газар /хэлтэс/-ийн даргын шийдвэр гарсны дараа үндсэн хөрөнгө актлахтай холбогдсон материалыг Төрийн өмчийн хорооны 2012 оны 44 дүгээр тогтоолоор баталсан журмын 1.9-1.12-д заасны дагуу бүрдүүлж, аймаг, нийслэлийн улсын бүртгэлийн хэлтэс Ерөнхий газарт, Ерөнхий газар Төрийн өмчийн хороо болон эрх бүхий байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулна.

2.7. Эд хөрөнгө олж авах, балансаас балансад шилжүүлэх, худалдах, актлах талаар гарсан эрх бүхий байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх, тайлагнах ажлыг холбогдох журмын дагуу хянаж, удирдан зохион байгуулна.

2.8. Хөрөнгө оруулалтаар авсан үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтаар хийгдсэн барилгын их засварын өртөг, мөн хандив бэлэг тусламж, төслөөр авсан үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан байдалд хяналт тавина.

2.9. Түрээсийн орлого, түүний төвлөрүүлэлт, зарцуулалт, түрээсийн байрны ашиглалтанд хяналт тавина.

2.10. Төрийн өмчийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж, журмыг мөрдөж ажиллахыг байгууллагын дарга болон холбогдох бусад ажилтнаас шаардах, тайлбар гаргуулах, эрх барих дээд байгууллага үндсэн хөрөнгийн тухай асуудлыг хэлэлцэхэд санал, зөвлөмж гаргах эрхтэй.

2.11. Байгууллагын хагас жилийн болон жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын ажилд хяналт тавьж, дүгнэлт өгнө. Шаардлагатай гэж үзвэл хяналтын тооллого хийх эрхтэй.

Гурав. Зөвлөлийн хурлын зохион байгуулалт

3.1. Зөвлөл нь улирал тутам нэгээс доошгүй удаа хурлаа хийж, байгууллагын өмч хөрөнгийн бүртгэл, эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдлын талаар дүгнэлт гаргаж, хийсэн ажлынхаа талаар тайлан гаргаж хамт олонд мэдээлнэ.

3.2. Зөвлөлийн дарга хурлыг товлон хуралдуулна.

3.3. Хурлыг зөвлөлийн дарга удирдах бөгөөд гишүүдийн дийлэнх олонхи оролцсон тохиолдолд хүчин төгөлдөр болно. Зөвлөлийн даргын эзгүйд түүний итгэмжилсэн зөвлөлийн гишүүн удирдана.

3.4. Хурлаар хэлэлцэх асуудлыг Зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах зарчмаар боловсруулсан байна. Үүнд:

- Үндэслэл
- Танилцуулга
- Дүгнэлт

3.5. Хурлаар асуудал хэлэлцэхдээ дараах дарааллыг баримтлана. Үүнд:

- 3.5.1. Зөвлөлийн дарга хэлэлцэх асуудлыг танилцуулах;
- 3.5.2. Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон асуулт, хариулт явуулах;
- 3.5.3. Зөвлөлийн гишүүд санал хэлэх;
- 3.5.4. Хурлын дарга хэлэлцэж буй асуудлын талаар гаргах дүгнэлтийн төсөл танилцуулах;
- 3.5.5. Дүгнэлтийг санал хурааж батлах;

3.6. Хурлын дүгнэлт нь хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно. Дүгнэлтийг газар хэлтэс-ийн даргын тушаалаар баталгаажуулна.

3.7. Хурлын тэмдэглэлийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хөтөлж, зөвлөлийн дарга, гишүүдээр гарын үсэг зуруулж баталгаажуулна.

3.8. Хүндэтгэх шалтгаанаар хуралд оролцох боломжгүй болсон гишүүний саналыг бичгээр авсан байна.

3.9. Зөвлөлийн гишүүдийн хурлын ирцийг нарийн бичгийн дарга бүртгэж, улирал бүрийн эцэст гишүүн бүрээр хуралд оролцсон байдал, гаргасан санал, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг танилцуулна.

Дөрөв. Хүлээх хариуцлага

4.1. Өмч хамгаалах байнгын зөвлөл Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн өмчийн хорооны тогтоолоор баталсан "Төрийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө олж авах, эзэмших, ашиглах, худалдах, шилжүүлэх, актлах журам"-ын 8 дах заалтын дагуу хариуцлага хүлээнэ.